“Сэндли ББСБ” ХК-ийн хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагнал

| Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | | |
|---|---|---|
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. | | |
| | | |
| Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/ | | 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | | “Сэндли ББСБ” ХК,<br>УБГД: 9015003084<br>ҮЦК: MSE, SEND<br>Утасны дугаар: (976) 7017-7700 |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр | | “Монголын Хөрөнгийн Бирж” ХК |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | | Банк бус санхүүгийн байгууллага |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | | 223,570,000 |
| Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | | Бэлтгэсэн:<br>Санхүү хариуцсан захирал: М.Мөнхгэрэл<br>Хянасан:<br>Гүйцэтгэх захирал: Б.Одгэрэл |
| | | |
| 1. | Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ | |
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | Тайланг хавсаргав |
| | Орлогын тайлан | Тайланг хавсаргав |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | Тайланг хавсаргав |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | Тайланг хавсаргав |
| | | |
| 2. | Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт | |

<table>
<tr><td></td><td colspan="2">Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 7 сарын 18-ны өдрийн хурлаар компанийн 2023 оны хагас жилийн аудитлагдаагүй санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсэн.</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="2">Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</td></tr>
<tr><td>3.1.</td><td>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</td><td rowspan="2"><table>
<tr><th>Харьцаа үзүүлэлт</th><th>%</th></tr>
<tr><td>Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа</td><td>41.9%</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа</td><td>42.0%</td></tr>
<tr><td>Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа</td><td>43.1%</td></tr>
<tr><td>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа</td><td>18.4%</td></tr>
<tr><td>Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа</td><td>78.7%</td></tr>
<tr><td>Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа</td><td>0.3%</td></tr>
<tr><td>Хөрөнгө /актив/-ийн өгөөж</td><td>6.0%</td></tr>
<tr><td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td><td>13.5%</td></tr>
</table></td></tr>
<tr><td>3.2.</td><td>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</td></tr>
<tr><td>3.3.</td><td>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</td><td><ul><li>ББСБ нь Монголын ТоС холбоотой гишүүнчлэлээр хамтран ажилладаг. Тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжлийг хангах үүднээс “Ногоон зээл”-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг 2023 оны 04-р сарын 24-ны өдөр батлан харилцагчдаа санал болгож байна.</li><li>СЗХ-оос баталсан “Зээлийн үйл ажиллагааны журам” Финтек бүтээгдэхүүнд тавигдах шаардлагад нийцүүлэн 2023 оны 06 сарын 01-ны өдрөөс цахим зээл болон бусад зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.</li></ul></td></tr>
<tr><td>3.4.</td><td>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</td><td>Санхүүгийн байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</td></tr>
<tr><td>4.</td><td colspan="2">Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Сонирхлын зөрчилтэй хэлцэл<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар сонирхолын зөрчилтэй 2 гэрээ байгуулсан:</td></tr>
</table>

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай” тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Мони маркет фанд ХХК-тэй 49 репо хэлцэл
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай” тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу Монголын финтек групп ХК-тай нэг улиралд нийт 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнтэй хэлцэл хийх гэрээг тус тус хийсэн.

**Их хэмжээний хэлцэл**

Тайлант хугацаанд Компани ямар нэгэн их хэмжээний хэлцэл хийгээгүй.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Компани тайлант хугацаанд олон нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаагүй.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Сэндли ББСБ ХК нь нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. “Сэндли ББСБ” ХК-ийн ХЭХ-ын хурал 2023 оны 04 сарын 07-ны өдөр болж доорхи асуудлуудыг хэлэлцсэн:

- Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна. Компанийн ТУЗ нь 9 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүн байна. 2022 оны 11 сарын 17-ны хурлаар сонгогдсон ТУЗ-ийн гишүүд:

| **Ердийн гишүүд** | **Хараат бус гишүүд** |
|---|---|
| Б.Наранбат (ТУЗ-ын дарга) | Б.Анужин |
| М.Цолмон | Ц.Саруултуяа |
| Б.Эрдэнэ | Б.Цэлмэг |
| Л.Нарантуяа | |
| Н.Билгүүн | |
| Н.Цэвэгмэд | |

ТУЗ-ын ээлжит хурал 2023 оны 02 сарын 06-ны өдөр зохион байгуулагдаж доорхи асуудлуудыг хэлэлцлээ:
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- Компанийн 2022 оны үйл ажиллааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт батлах тухай
- Ногдол ашиг хуваарилах тухай
- Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоож, гэрээний нөхцөл батлах тухай
- Компанийн 2023 оны санхүүгийн болон бизнесийн төлөвлөгөөг батлах тухай
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай
- Салбарын хаяг өөрчлах тухай

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

2023 оны хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд холбогдох дээд албан байгууллагуудад илгээн, олон нийтэд mse.mn болон sendly.mn сайтаар тайлагнасан байна.

- 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
- 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан

| |
|---|
| Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: Б.Одгэрэл<br><br>Албан тушаал: "Сэндли ББСБ" ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ……………………………………<br><br>(Тамга/тэмдэг) |
| Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: |
| Овог, нэр: М.Мөнхгэрэл<br><br>Албан тушаал: Санхүү хариуцсан захирал<br><br>Гарын үсэг: …………………………………….. |